



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/397

Хэрлэн сум

Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн
тооллогыг зохион байгуулж,
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.5, 26 дугаар зүйлийн 26.1, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт" Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам"-ын 2.2, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/648 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээний нутаг дэвсгэрийн төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг 2018 оны 11 дүгээр сарын 12-оос 2019 оны 3 дугаар сарын 31-ийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Тооллогын ажлыг нэгдсэн арга зүйгээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга:	С.Мөнхцэцэг	-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Гишүүд	Н.Нямсүрэн	-Музейн захирал
	Ц.Мөнгөнзул	-АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Отгонцолмон	-Мэргэжлийн хяналтын газрын боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч
	Д.Баатарцогт	-Боловсрол, соёл, урлагийн газрын соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Г.Бүрэнтөгс	-Музейн эрдэм шинжилгээний ажилтан
	Э.Сайнзаяа	-Музейн арга зүйч, тайлбарлагч
	Д.Зоригтбаярмаа	-Орон нутгийн өмчийн газрын бүртгэл хяналтын мэргэжилтэн
Т.Отгонтуяа	-Аймгийн нийтийн номын сангийн сан хөмрөгч	

2//.

Нарийн бичгийн
дарга:

Б.Өнөрбаяр

-Музейн бүртгэл мэдээллийн санч

3. Тооллогын ажлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, нэгдсэн дүн, цаашид авах арга хэмжээний саналыг аймгийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсэг / С.Мөнхцэцэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text: "МОНГОЛ" (Mongolia) at the top, "Музейн бүртгэл мэдээллийн санч" (Museum Registration and Information Office) in the middle, and "Засаг дарга" (Director) at the bottom. The signature is written across the stamp and extends to the left.

Н.ГАНБЯМБА